Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Бүрэн сумын ЗДТГ нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь 2018 онд аймгийн хэмжээнд батлагдсан НББ-ын бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөж байгаа ба тус бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Бүрэн сумын ЗДТГ нь 2022 оны санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 50,831.8 мянган төгрөгөөр буюу 3,5 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Урьдчилгаа	0	0	0
Авлага	576.5	200.5	-376.0
Бараа материал	56,427.6	66,473.3	10,045.7
Үндсэн хөрөнгө	3,113,774.8	3,313,874.2	200,099.4
Нийт хөрөнгө	3,170,778.9	3,380,548.0	209,769.1
Өр төлбөр	2,970.1	425.9	2,544.2
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	3,167,808.9	3,380,122.1	212,313.2
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,170,778.9	3,380,548.0	209,769.1

Дээрх хүснэгтээс харахад: Авлагын оны эхний үлдэгдэл 576.5 мянган төгрөгөөс 228.3 мянган төгрөг болж, 348.2 мянган төгрөгөөр буурсан байна.

Бараа материалын дансны эхний үлдэгдэл 56,427.6 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр 56,406.5 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, ХХААГ-аас 3,700.0 мянган төгрөгийн 18 хурган хуц, 5 төлгөн хуцыг үнэ төлбөргүйгээр хүлээн авч, 48,966.5 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, 1,094.4 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, аж ахуйн материалыг

актлаж устгаснаар бараа материалын эцсийн үлдэгдэл 66,473.3 мянган төгрөг болж, 10,045.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Өвөлжилтийн байдлыг хангах зорилгоор малын хивэг тэжээл 4,080.0 мянган төгрөгөөр, ХХААГ-аас 3,700.0 мянган төгрөгийн 23 хуц авсан зэрэг нь бараа материалын өсөлтөд нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгийн дансны эхний үлдэгдэл 3,113,774.8 мянган төгрөг, сумын ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 19-ний 04 дүгээр тогтоолоор төсвийн шилжих үлдэгдлийн хөрөнгөөр 23,390.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 29,893.8 мянган төгрөгийн үерийн далангийн зураг, 10,520.0 мянган төгрөгийн нарны зүйн гэрэлтүүлэг, 19,000.0 мянган төгрөгийн гэрэлт гудамж, 28,692.7 мянган төгрөгийн тавилга эд хогшил компьютер тоног төхөөрөмж, нийт 111,496.5 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, ОНХС-ийн хөрөнгөөр 135,497.2 мянган төгрөгийн дулааны шугам сүлжээг сайжруулалтаар, 75,411.5 мянган төгрөгийн хогийн цэг, 45,000.0 мянган төгрөгийн малын худаг, цагдаагийн газраас 4,500.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл зэрэг нийт 104,920.6 мянган төгрөгийн хөрөнгүүдийг үнэ төлбөргүйгээр орлого авч, сумын ИТХ-ын 2022 оны 6 дугаар сарын 30-ны хуралдааны 06 дугаар тогтоолоор 9,686.2 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл акталж устгаснаар, үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 3,313,874.2 мянган төгрөг болсон байна. Тайлант оны хөрөнгийн элэгдлийн зардал 167,911.9 мянган төгрөгөөр бүртгэж, хөрөнгийн үлдэгдэл өртөг 299,099.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,313,874.2 мянган төгрөг болж 200,099.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 493,735.2 мянган төгрөг, зарлагыг 493,735.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төв аймгийн Бүрэн сумын ЗДТГ-ын хүргүүлсэн төсвийн төслөөс 104,254.6 мянган төгрөгөөр бууруулж, аймгийн ИТХ-ын 2021 оны 07 дугаар тогтоолоор 389,480.6 мянган төгрөгийн төсөв 2022 оны санхүүгийн жилд зарцуулж, орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр батлагдаж ирсэн байна.

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 493,735.2 мянган төгрөг, зарлагыг 493,735.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төв аймгийн Бүрэн сумын ЗДТГ-ын хүргүүлсэн төсвийн төслөөс 104,254.6 мянган төгрөгөөр бууруулж, аймгийн ИТХ-ын 2021 оны 07 дугаар тогтоолоор 389,480.6 мянган төгрөгийн төсөв 2022 оны санхүүгийн жилд зарцуулж, орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр батлагдаж ирсэн байна.

Тайлант хугацаанд сумын ИТХ-ын 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 8 дугаар хуралдааны 05 тоот тогтоолоор тодотгол хийж, нийт 218,210.0 мянган төгрөгийн төсөл арга хэмжээг сумын шилжих үлдэгдлээс санхүүжүүлэхээр тодотгол оруулж нийт зардлыг 607,690.6 мянган төгрөгөөр, зардал санхүүжүүлэх эх үүсвэрийг 607,690.6 мянган төгрөгөөр орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөв 389,480.6 мянган төгрөгийг 218,210.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 1 удаа тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэх 604,700.6 мянган төгрөг, хүрээлэн буй орчны бодлого, удирдлага хөтөлбөрийн 1 арга хэмжээг санхүүжүүлэх 2,900.0 мянган төгрөг, нийт 607,600.6 мянган төгрөгийн зардлыг, орон нутгийн төсвөөс 389,480.6 мянган төгрөг, шилжих үлдэгдлээс 218,120.0 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсны дагуу гүйцэтгэлээр зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 100 хувь олгож, оны эцэст зарцуулаагүй үлдэгдэл 23,587.0 мянган төгрөгийг төсөвт татан төвлөрүүлсэн байна.

Тайлант хугацааны төсвийн нийт зардлын гүйцэтгэл 584,013.6 мянган төгрөг буюу 96,1 хувьтай байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаж, цалингийн зардлаас 12,773.8 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас 3,089.1 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 1,301.9 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх бараа үйлчилгээний зардлаас 6,257.7 мянган төгрөг нийт 23,587.0 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдлийг татан төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	/мянган төгрөгөөр/		
			Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70106-Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 80101- Үндсэн үйл ажиллагааны зардал	254,989.3	242,348.5	12,640.8	95.0%
2	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 80103- Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	41,129.6	31,471.0	9,658.6	76.5%
3	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 80106- Баг, хорооны үйл ажиллагааны зардал	67,332.2	66,044.6	4,636.8	98.1%
4	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 80802- Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	13,129.5	13,129.5	0	100%
5	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 80918- Бусад	218,120.0	218,120.0	0	100%
6	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 81102- Орон нутгийн нөөц хөрөнгө	5,000.0	5,000.0	0	100%
7	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 82801- Улсын их баяр наадам	5,000.0	5,000.0	0	100%
8	71411- Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага 82212- Хур хог хаягдал, орчны бохирдол	2,900.0	2,900.0	0	100%
	Дүн	607,600.6	584,013.6	23,587.0	96.1%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Бүрэн сумын Засаг даргын тамгын газар нь 2022 онд нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн ЗДТГ- аас малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх шатахууны зардалд 1,166.4 мянган төгрөг, сонгуулийн үр дүнд ажлаас чөлөөлөгдсөн улс төрийн 2 албан хаагчийн нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 7,560.0 мянган төгрөг, урианы жилийн урамшуулалд 200.0 мянган төгрөг, аймгийн хөрөнгө оруулалтаас 12,000.0 мянган төгрөг, статистикийн хэлтсээс ээлжит тооллогын болон тандалт судалгааны зардалд 3,670.8 мянган төгрөг, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас ажил зуучлалын зардалд 66.0 мянган төгрөг, цахим тендерийн хураамж 469.0 мянган төгрөг, нохойн хураамж 1,155.0 мянган төгрөг, өвсний үнэнд 3,587.5 мянган төгрөг, өмнөх оны татан төвлөрүүлсэн нэмэлт санхүүжилтийн орлого 16,099.5 мянган төгрөг, нийт 45,974.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх шатахууны зардалд 1,166.4 мянган төгрөг, сонгуулийн үр дүнд ажлаас чөлөөлөгдсөн улс төрийн 2 албан хаагчийн нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 7,560.0 мянган төгрөг, урианы жилийн урамшуулалд 200.0 мянган төгрөг, тооллого судалгааны арга хэмжээнд 3,663.8 мянган төгрөг, өвс хивэг худалдан авахад 7,785.0 мянган төгрөг, оготнын хор авахад 2,500.0 мянган төгрөг, бусад зардалд 2,396.6 мянган төгрөг, нийт 25,271.8 мянган төгрөгийг зарцуулж, тайлант онд зарцуулаагүй 20,702.4 мянган төгрөгийг татан төвлөрүүлж тайлагнасан байна.

Нэмэлт санхүүжилтийн орлого, зардлыг зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.5 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт хоёр хөтөлбөрийн найман арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/						
№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70106-Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	2022.01.01-2022.12.31	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	Бүрэн хэрэгжсэн, биелэлт 96.1%	604,700.6	581,113.6
2	71411- Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	2022.01.01-2022.12.31	Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	Бүрэн хэрэгжсэн, биелэлт 100%	2,900.0	2,900.0
Нийт төсвийн дүн					607,600.6	584,013.6

Төв аймгийн Бүрэн сумын Засаг даргын тамгын газрын 70106 хөтөлбөр 96,1 % буюу 20,702.4 мянган төгрөгөөр дутуу хэрэгжсэн нь 80101 арга хэмжээний үндсэн үйл ажиллагааны зардал 95 хувьтай, 80103 арга хэмжээний гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний зардал 76,5 хувьтай, 80106 арга хэмжээний баг хорооны ажил, үйлчилгээний зардал 98,2 хувьтай гүйцэтгэл гарснаас хамаарч байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Бүрэн сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Баянжаргал гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Бүрэн сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 03/16 тоот албан бичгээр Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Бүрэн сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны баталсан төсвийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Бүрэн сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсвийн нийт зарлага 554,280.6 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 8,314.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 6,235.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага авч хэрэгжүүлсэн ажлын тайланг 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай хамт хавсаргаж, ирүүлсэн.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаж, цалингийн зардлаас 12,773.8 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас 3,089.1 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 1,301.9 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх бараа үйлчилгээний зардлаас 6,257.7 мянган төгрөг нийт 23,587.0 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдлийг татан төвлөрүүлсэн байна.

“Ээлжийн амралтаараа дотоодын амралт, сувиллын газарт, эсхүл өөрийн болон эхнэр /нөхөр/-ийн төрсөн нутагт амрах тохиолдолд түүний очих, ирэх замын зардлыг олгохгүй” байх заалтын дагуу Бүрэн сумын Засаг даргын тамгын газрын алба хаагчдад 2022 онд замын зардал олгоогүй, хууль тогтоомжид зааснаас бусад хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгоогүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Бүрэн сумын Засаг даргын тамгын газрын шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад Тендер шалгаруулсан худалдан авах ажиллагааны 2 мэдээлэл, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 12 орлогын, 34 зарлагын мөнгөн гүйлгээнээс орлогын 2 гүйлгээний мэдээллийг хугацаа хоцроож, зарлагын 9 гүйлгээг байршуулаагүй бөгөөд өмч хөрөнгө, мөнгө зарцуулах 51 шийдвэрийг хугацаанд нь байршуулснаар шилэн дансны хэрэгжилт 89,7 хувьтай байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Бүрэн сумын Засаг даргын тамгын газрын санхүүгийн тайланд завсрын аудит хийгдсэн. Завсрын аудитын явцад асуудлын бүртгэлээр 4 зөвлөмж өгөгдсөн ба биелэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад 2 зөвлөмж нь үр дүнтэй хэрэгжсэн тул аудитын тайланд тусгаагүй болно.

Шилэн дансны хэрэгжилт, шилжих үлдэгдлийн зарцуулалтын талаар өгсөн зөвлөмжийг хангалтгүй хэрэгжүүлсэн гэж үзэн энэхүү тайланд тусгаж, зөвлөмж хүргүүллээ.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар 3 албан шаардлага, 2 зөвлөмж өгөгдсөнийг 100% хэрэгжүүлэн, биелэлтийг 2022 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 03/144 тоотоор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	0	0.0	0	0.0	0%
Албан шаардлага	3	20,211.9	3	20,211.9	100%
Зөвлөмж	2	3,873.0	2	3,873.0	100%
Нийт дүн	5	24,084.9	5	24,084.9	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Бүрэн сумын Засаг даргын тамгын газрын дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудлаар орон нутгийн шилжих үлдэгдлээс санхүүжүүлж байгаа хөрөнгийн зардлын зарцуулалт болон нэмэлт санхүүжилтийн данснаас бэлчээрийн худаг гаргах ажилд 12,000.0 мянган төгрөг санхүүжүүлснийг хэрхэн хэрэгжүүлж зарцуулсан байдлыг тодорхойлж байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн үр дүнгийн тайланд цалин 5,776.1 мянган төгрөгөөр, шимтгэл 1,754.6 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой зардлууд 5,575.9 мянган төгрөгөөр, дотоод албан томилолтын зардал 167.3 мянган төгрөгөөр, элэгдлийн зардал 2,082.9 мянган төгрөгөөр, нийт 15,356.3 мянган төгрөгийн алдаатай тайлагнасныг аудитын явцад Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу залрууллаа.

Аудитаар нийт 20,492.9 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 1,070.9 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 4,122.0 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 15,300.0 мянган төгрөгийн 2 зөрчилд дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

5.1 Төлбөрийн акт

Байгууллагын дотоод журмын дагуу албан хаагчдад олгох нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлын төсвөөс 900.0 мянган төгрөгийн тэтгэмжийг сумын иргэдэд олгосон зөрчил байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалттай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн “эрх ба үүрэг”, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МҮЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” бол төлбөрийн акт тогтооно гэсний дагуу шийдвэрлэв.

Сахилгын шийтгэлтэй ажилтанд 170.9 мянган төгрөгийн үр дүнгийн мөнгөн урамшуулал олгосон зөрчил байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “хариуцлагатай байх”, МУ-ын ЗГ-ын 2019 оны “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох тухай” 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 2 дугаар заалтын 2.7-д “Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй” гэсэн заалттай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн “эрх ба үүрэг”, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МҮЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.3-д “цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон” бол төлбөрийн акт тогтооно гэсний дагуу шийдвэрлэв.

5.2 Албан шаардлага

Бараа үйлчилгээний зардлаас 4,122.0 мянган төгрөгийг дотоод албан томилолтын зардалд гүйлгэн зарцуулсан зөрчил байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3-д “сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн аудитын “ангилал”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон МҮЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.6-д “төсвийг зориулалт бусаар зарцуулсан” бол албан шаардлага хүргүүлэх гэсний дагуу шийдвэрлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1.Илрүүлэлт:

Шилжих үлдэгдлээс санхүүжүүлсэн хөрөнгийн зардлаас эрүүл мэндийн төвийн 13,000.0 мянган төгрөгийн, соёлын төвийн 2,300.0 мянган төгрөгийн өрийг төлсөн зөрчил байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “жинхэнэ хэрэгжилтийн” зарчим, Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ний 190 дугаар тушаалаар батлагдсан “зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”- тай нийцэхгүй бөгөөд санхүүгийн тайлангийн “ангилал”, “тасалбар болголт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2.Өгсөн зөвлөмж:

Шилжих үлдэгдлээс санхүүжүүлсэн хөрөнгийн зардлыг тухайн төсвийн жилд үл хөдлөх хөрөнгө бий болгох, барилга байгууламж, тоног төхөөрөмж худалдан авах, барилга байгууламжид их засвар хийх, стратегийн шинжтэй бараа бүтээгдэхүүнтэй холбоотой зардалд зарцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

2. Нийцлийн аудиттай холбоотой асуудал

2.1.Илрүүлэлт:

Шилэн дансанд байршуулах хөрөнгө зарцуулах 76.136.5 мянган төгрөгийн 9 шийдвэрийг байршуулаагүй, шилэн дансны хэрэгжилт 89,7 хувьтай зөрчил байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.2-д "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх" 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэж заасантай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн аудитын "толилуулга", "эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

2.2.Өгсөн зөвлөмж:

Үнэн зөв, бодитой, ойлгомжтой, иж бүрэн мэдээллийг хуулийн хугацаанд нь байршуулж хэвших.

Дээрх акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА,ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

мянган төгрөгөөр

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуул- сан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
							залруулсан		залруулаагүй			
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
Санхүүгийн үр дүнгийн тайланд цалин 5,776.1 мянган төгрөгөөр, НДШ 1,754.6 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой зардлууд 5,575.9 мянган төгрөгөөр, дотоод албан томилолтын зардал 167.3 мянган төгрөгөөр, элэгдлийн зардал 2,082.9 мянган төгрөгөөр, нийт 15,356.3 мянган төгрөгийн алдаатай тайлагнасан байна.	1	15,356.3			1	15,356.3	1	15,356.3				
Дүн	1	15,356.3	0	0.0	1	15,356.3	1	15,356.3	0	0.0	0	0.0

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

мянган төгрөгөөр

Алдааны товч утга	Нийт зөрчил		Үүнээс:									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	тоо	дүн										
Байгууллагын дотоод журмын дагуу албан хаагчдад олгох нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлын төсвөөс 900.0 мянган төгрөгийн тэтгэмжийг сумын иргэдэд олгосон зөрчил байна	1	900.0	1	900.0								
Сахилгын шийтгэлтэй ажилтанд 170.9 мянган төгрөгийн үр дүнгийн мөнгөн урамшуулал олгосон зөрчил байна	1	170.9	1	170.9								
Бараа үйлчилгээний зардлаас 4,122.0 мянган төгрөгийг дотоод албан томилолтын зардалд гүйлгэн зориулалт бусаар зарцуулсан зөрчил байна.	1	4,122.0			1	4,122.0						
Шилжих үлдэгдлээс санхүүжүүлсэн хөрөнгийн зардлаас эрүүл мэндийн төвийн 13,000.0 мянган төгрөгийн, соёлын төвийн 2,300.0 мянган төгрөгийн өрийг төлсөн зөрчил байна.	1	15,300.0					1	15,300.0				
Дүн	4	20,492.9	2	1,070.9	1	4,122.0	1	15,300.0	0	0.0	0	0.0

6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

мянган төгрөгөөр

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс:					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансанд байршуулах хөрөнгө зарцуулах 76.136.5 мянган төгрөгийн 9 шийдвэрийг байршуулаагүй, шилэн дансны хэрэгжилт 89.7 хувьтай зөрчил байна.	1						1	
Дүн	1	0.0	0	0.0	0	0.0	1	0.0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн	0	0.0	0	0.0	0	0.0	0	0.0
Нийт дүн	0	0.0	0	0.0	0	0.0	0	0.0